



**ЖЕНКО ТУР
БЮРО ХК**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХУРЛЫН ТОВ

№ 3

Хурал болсон газар	Төв аймгийн Эрдэнэ сум, ЧХМХЦ-т танхим
Он сар өдөр	2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр хуралдав.
Хурлын цаг	11:00-16:00 цагт боллоо.

ХУРЛЫН ИРЦ

Хурлын дарга	ТУЗ-ийн дарга Ц.Түмэнхишиг
Хурлын ирц	63,8%
Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид	19 хувьцаа эзэмшигчид

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг батлах
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах

Тооллогын комиссын дарга Х.Оюунтуяа:

ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 29 өдөр

№ 1

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 67.3.1, 69.1, 69.2, 69.8 болон “Женко тур бюро” ХК-ийн дүрмийн 3.15, “Женко тур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Женко тур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 51,060,521 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 19 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 79,988,802 ширхэг энгийн хувьцааны 63,8% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дох заалт, компанийн дүрмийн 3.15 дахь заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 63,8%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга Ц.Түмэнхишиг: Нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Женкотур бюро ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэнээр өнөөдөр хуралдах боломжтой болсон байна. Хурлын дэгийн та бүхэнд танилцуулъя.

- Хурлын ирцийг бүртгэх
- Хурлын ирцийг мэдээлэх
- Хурлын дарга хурлыг нээх
- Компанийн танилцуулга
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах
- Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг танилцуулах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах
- Хурлаас гарах шийдвэртэй холбогдсон асуулт хариулт
- Саналын хуудас бөглөх заавар танилцуулах
- Санал хураалт
- Хурлын завсарлага
- Тооллогын комиссын тогтоол, шийдвэрийг танилцуулах
- Хурлаас гарах тогтоолыг танилцуулах
- Хурлын дарга хурлыг хаах гэсэн дараалалтай явна.

Компанийн танилцуулгыг хурлын дарга Ц.Түмэнхишиг танилцууллаа.

Ц.Түмэнхишиг: Манай компанийн эрхэм зорилго нь Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох зорилготой. 1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хувьцаат Компани болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

2025-2026 онд ТУЗ-ийн даргаар Ц.Түмэнхишиг, гүйцэтгэх захирлаар Б.Намуун ажиллаж байна.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдож бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 8 хурал биеэр болон эчнээ саналын хуудсаар зохион байгуулж улирал бүрийн үйл ажиллагаа, төлөвлөгөөтэй танилцан холбогдох шийдвэр зөвлөмжийг өгч ажилласан.

Ерөнхий менежер Ч.Гэрэл: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан,, хараат бус аудитын дүгнэлт, 2026 оны төлөвлөгөө, ТУЗ-ийн зардлын төсөвийн талаар хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд танилцууллаа.

Эргэлтийн хөрөнгийн харьцаа:

№	Үзүүлэлтийн нэр	2025 он /Мянга төг/
1	Эргэлтийн хөрөнгө	7,095,922,618.89
2	Эргэлтийн бус хөрөнгө	7,226,499,066.35
	Нийт хөрөнгө	14,322,421,685.24

Эх үүсвэрийн харьцаа:

№	Үзүүлэлт	2025 он /Мянга төг/
1	Өр төлбөр	1,387,860,284.69
2	Эздийн өмч	12,413,878,266.27
	Нийт хөрөнгө	14,322,421,685.24

Орлогын тайлангийн шинжилгээ:

№	Үзүүлэлт	2025 он /Мянга төг/
1	Нийт орлого	5,318,055,714.55
2	ББӨ	2,325,112,359.7
3	ТТӨА	2,992,943,354.85

2024 болон 2025 оны борлуулалтын харьцаа:

Орлогын төрөл	2025 оны төлөвлөгөөний биелэлт
ЧХМХ Цогцолбор	4,973,121,714
13-р зуун Цогцолбор	107,010,900
Аялал /гадаад, дотоод/	237,923,100
Нийт дүн	5,318,055,714.55

Хувьцаа эзэмшигчдийн хуралд санхүүгийн дээрхи мэдээллийг танилцууллаа.

2025 онд Интер аудит ХХК хараат бус аудитын ажлыг хийсэн.

“Женкотур бюро” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.” гэж дүгнэсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЖЕНКОТУР БЮРО” ХК-ИЙН УДИРДЛАГАД

Дүгнэлт

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “ЖЕНКОТУР БЮРО” ХК (цаашид “Компани” гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж буйгаар “ЖЕНКОТУР БЮРО” ХК-ийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал ба жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө

№	Үзүүлэлт	2025 он	2026 төлөвлөгөө
1	Нийт орлого	5,318,055,714.55	7,199,215,700.00
2	ББӨ	2,325,112,359.7	3,854,458,572.94
3	Татварын өмнөх ашиг	2,992,943,354.85	3,344,757,127.07
4	ОАТ зардал	299,294,335.48	334,475,712.71
5	Цэвэр ашиг	2,693,649,019.37	3,010,281,414.36

2026 оны зардлын төлөвлөгөө

Нийт өртөгийн тооцоолол	2025 оны гүйцэтгэл	2026 төлөвлөгөө
ЧХМХ Цогцолбор	2,828,595,959	3,160,557,455.94
13-р зуун Цогцолбор	105,052,051	200,000,000
Аялал /гадаад, дотоод/	160,750,851	373,611,600.00
Нийт үйл ажиллагааны зардал	106,450,900.00	120,289,517.00
Нийт зардалын дүн	3,200,849,761	3,854,458,572.94

2026 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сегмент	2025 гүйцэтгэл	2026 төлөвлөгөө	Өсөлт
ЧХМХ Цогцолбор	4.97т.бум	5.79т.бум	+16%
13-р зуун Цогцолбор	149сая	164сая	+10%
Аялал /гадаад, дотоод/	189сая	1.24т.бум	+558%
Нийт	5.30В	7.19В	+35%

Мөн 2026 онд хэрэгжүүлэх 12 сарын ажлын төлөвлөгөөг календарчлан үзүүлж, танилцуулав.

ТУЗ-ийн үйл ажиллагааны жилийн зардлын төсөв

Д/д	Зардлын төрөл	НИЙТ ЗАРДАЛ м.төг
1	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин	12,830,400
2	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин	6,000,000
3	НДШ, ХАОАТ зардал	3,041,640
4	Үйл ажиллагааны зардал	1,000,000
Дүн		22,872,040

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Саранчимэг:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн танилцуулав.


ТУЗ-ийн ердийн гишүүдэд:

Х.Цэндбаяр, Д.Цэрэнчимэг, Б.Октябрь, Б.Намуун, Б.Номин, Б.Оргилболд Б.Оргилбат

Хараат бус ТУЗ-ийн гишүүдэд:

Ц.Түмэнхишиг, А.Баярмаа, Б.Энхбат нарыг танилцуулж, ердийн гишүүнд 6, хараат бус гишүүнд 3 нэр дэвшигчдийг сонгох тухай саналын хуудасны зааварчилгаа өглөө.

Хурлын дарга: ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулав.



Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээн дэх асуулт, хариулт:

Хувьцаа эзэмшигч: ТУЗ-ийн ердийн гишүүд цалин урамшуулал авдаг уу?

Хурлын дарга Ц.Түмэнхишиг: Манай ТУЗ-ийн ердийн гишүүд нь сайн дурын үндсэн дээр ажилладаг учир цалин авдаггүй.

Хувьцаа эзэмшигч: Аялал жуулчлалаас яаж өндөр орлого олох вэ?

Энэ жил монгол улс аялал жуулчлал жил гэж зарласнаас үүсэн, жуулчдын урсгал нэмэгдэх төлөвлөгөөтэй гэж харсан учраас аяллын багийн төлөвлөгөө болон орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн төлөвлөсөн.

Хувьцаа эзэмшигчид асуулт асууж, асуултын хариулт авав.

Тооллогын комиссын дарга Х.Оюунтуяа: Хувьцаа эзэмшигчидийн саналын хуудсыг үндэслэн тооллогын комиссын дүнг танилцуулав. /Тооллогын комиссын дүнгийн шийдвэрийг хавсаргав./

Хурлын дарга: ХЭ-ийн хурлаар санал хураалт амжилттай явагдаж дууслаа. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүддээ ажлын амжилт хүсч, компанийг үр ашигтай ажиллуулахын төлөө хамтран ажиллах болсонтой талархаж байна. Бүгдэнд амжилт хүсье. За тогтоол уншиж танилцуулъя.

Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, 2026 оны 04 сарын 29-ны өдрийн “Женко Тур Бюро” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Женко Тур Бюро” хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.
2. “Женко Тур Бюро” хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах

2026 оны 04 сарын 29-ны өдрийн “Женко Тур Бюро” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Женко тур Бюро” Хувьцаат компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

“Женко тур бюро” ХК-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

2026 оны 04 сарын 29-ны өдрийн “Женко Тур Бюро” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Женко Тур Бюро” хувьцаат компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт №1-ээр баталсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Женко Тур Бюро” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Женко Тур Бюро” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр
 1. Х.Цэндбаяр

2. З.Цэрэнчимэг
3. Б.Октябрь
4. Б.Намуун
5. Б.Оргилболд
6. Б.Оргилбат

Хараат бус гишүүнээр

7. Ц.Түмэнхишиг
8. А.Баярмаа
9. Б.Энхбат нарыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

“Женко тур бюро” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөв батлах тухай

2026 оны 04 сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тооллогын комиссын дүнг үндэслэн “Женко Тур Бюро” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Женко Тур Бюро” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсвийг Хавсралт №1-ээр баталсугай.

Хоёр. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

Хурлын дарга: ХЭ-ийн хуралд оролцсон, санал, зөвлөмжөө өгсөн, саналын хуудсаар оролцсон та бүхэндээ талархсанаа илэрхийлье. Шинээр ТУЗ-д сонгогдсон гишүүд, ажлын хамт олон амжилт хүсч, дэлхий даяар аялал жуулчлалын салбар сэргэж компани ашигтай ажиллах болтугай гэж хүсэн ерөөе.

Өнөөдрийн ХЭХурал хаасныг мэдэгдье.

Хурлын дарга:...../Ц.Түмэнхишиг/

Тэмдэглэл хөтөлсөн:...../З.Саранчимэг/

